



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 9/61

Мандалговь

"Мандал шилтгээн" ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Цэнгэлдэх хүрээлэнгийн өргөтгөл Шагайн харвааны асар" ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Мандал шилтгээн" ХХК-тай 49,951,782 (дөчин есөн сая есөн зуун тавин нэгэн мянга долоон зуун наян хоёр) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зураг, төсвийн дагуу "Цэнгэлдэх хүрээлэнгийн өргөтгөл Шагайн харвааны асар" ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "Мандал шилтгээн" ХХК-ийн захирал (Б.Ням)-д үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150384